

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Геополитикийн хурцадмал байдлаас болж хувьцаануудын ханш уналттай байлаа. Facebook компани хэрэглэгчийн мэдээллийг нууцаар ашигласан явдал Nasdaq индексийн уналтанд нөлөөлөв. АНУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар Хятад улсаас орж ирж байгаа 60 тэрбум ам.долллартай тэнцэх хэмжээний импортын бараанд тариф ногдуулах талаар мэдэгдэл хийсэн бол Хятад улсын эрх баригчид хариу болгон 3 тэрбум ам.долллартай тэнцэх АНУ-ын импортын бараанд татвар ногдуулна хэмээн мэдэгдсэн байна. Мөн энэ долоо хоногийн нэгэн чухал үйл явдал бол АНУ-ын Холбооны Нөөцийн сан улирал бүрийн бодлогын хүүг олны таамаглаж байсантай адил хэмжээгээр өсгөжээ.

Европ: Худалдааны дайн үүсэх магадлал нэмэгдэж байгаатай холбогдуулан Европын компаниудын хувьцааны ханш унаж 2017 оны эхнээс хойшхи хамгийн доод түвшинд хүрлээ. Ган, хөнгөн цагааны импортод ногдуулсан тарифаас Европын орнуудыг түр хугацаагаар чөлөөлсөн хэдий ч дэлхийн хоёр том эдийн засаг болох АНУ, БНХАУ хоорондын харилцаа хувьцааны ханшид сөргөөр нөлөөлж байна. Худалдааны дайнтай холбоотой тодорхойгүй байдал нь евро болон фунтийн ханшийг өсгөхөд хүргэжээ.

Япон: Хятад улсад ногдуулах шинэ тарифтай холбоотойгоор Японы хувьцааны ханш унав. Өмнөх ган, хөнгөн цагааны импортод ногдуулах тарифаас европын орнууд болон Өмнөд Солонгосыг чөлөөлсөн ч Япон улсыг тус жагсаалтанд оруулаагүй байна.

Хятад: Хятадын компаниудын хувьцааны ханш Баасан гарагт худалдааны дайны асуудалтай холбоотойгоор огцом унаж, сүүлийн зургаан долоо хоногийн доод түвшинд хүрсэн.

Монгол улс: Үнэт цаасны арилжаагаар 2018 оны 2 дугаар сарын эцэст 3.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 3.2 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх сараас гүйлгээ 231.3 (98.5%) тэрбум төгрөгөөр буурчээ. Арилжсан үнэт цаас өмнөх оны мөн үеэс 1.6 (34.0%) сая ширхгээр буурсан байна. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2018 оны 2 дугаар сарын эцэст 1.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн нь өмнөх сараас 230.4 (99.2%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 22.0 (92.2%) тэрбум төгрөгөөр буурчээ. Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2018 оны 2 дугаар сард 1116.0 нэгж болж, өмнөх сараас 31.21 нэгжээр буурч, өмнөх оны мөн үеэс 8993.78 нэгжээр өсөв. Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2018 оны 2 дугаар сард 2.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.9 (62.3%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Төгрөгийн америк доллартай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 2 дугаар сард 2402.9 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.0 хувь, өмнөх сараас 0.9 хувиар чангарчээ. Төгрөгийн юаньтай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2018 оны 2 дугаар сард 380.19 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.5 хувь, өмнөх сараас 0.8 хувиар суларчээ.

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	21,481.20	2.34 ▲
Dow Jones	АНУ	23,533.20	-5.67% ▼
S&P 500	АНУ	2,588.26	-5.95% ▼
Nasdaq	АНУ	6,992.67	-6.54% ▼
S&P/TSX	Канад	15,223.74	-3.10% ▼
FTSE 100	Их Британи	6,921.94	-3.39% ▼
S&P/ASX 200	Австрали	5,820.70	-2.16% ▼
Nikkei 225	Япон	20,617.86	-4.88% ▼
Hang Seng	Хонг Конг	30,309.29	-3.79% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	111.87
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.77
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	97.15
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	114.92
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.37
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.91
TDBM' 2020	USD	9.3%	107.63

Зах зээлийн хүү

ХҮҮ	Хаалт	ҮоҮ
Libor 1M	1.875	0.05 ▲
Libor 3M	2.292	0.09 ▲
Libor 6M	2.450	0.09 ▲
Libor 1YR	2.666	0.05 ▲
US 6M Bond	1.893	-0.03 ▼
US 2YR Bond	2.270	-0.02 ▼
US 3YR Bond	2.411	-0.04 ▼
US 5YR Bond	2.610	-0.04 ▼
US 10YR Bond	2.825	-0.03 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.03.23	Өөрчлөлт
USD	2,396.35	-0.04% ▼
CNY	378.71	-0.07% ▼
EUR	2,953.02	0.01% ▲
RUB	41.95	0.58% ▲
KRW	2.22	-1.33% ▼
JPY	22.82	0.57% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,347.33	2.52% ▲
Мөнгө /spot/	16.57	1.41% ▲
Зэс	299.30	-3.68% ▼
Нүүрс	90.42	-6.93% ▼
WTI газрын тос	65.88	5.68% ▲
Brent газрын тос	70.45	6.40% ▲
Байгалийн хий	2.59	-3.72% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляций түвшин	2018.11	6.90%
Бодлогын хүү	2018.11	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.11	11.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.11	12.90%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.11	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.11	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.11	11.50%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 59 компанийн 2,533.2 сая төгрөгийн 31,941,116 ширхэг хувьцаа арилжигдав.


“Хөвсгөл алтан дуулга” /ADU/ компанийн хувьцаа 32.16%-аар буюу хамгийн ихээр өсч 8,095 төгрөгт хүрч хаагдсан бол “Ар Баянхангай” /ABH/ компанийн хувьцаа 21.74%-аар буурч 900 төгрөгт хүрч хаагдлаа.

Тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

Мөн хоёрдогч зах зээл дээр компанийн бонд арилжигдаагүй байна.


3-р сарын 23-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,651.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,481.20 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.34%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,533.2
Зах зээлийн үнэлгээ	2,651,390.2

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,481.20	2.34% ▲
MSE I индекс	10,932.81	3.28% ▲
MSE II индекс	10,068.59	1.25% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	31,126,081	1,683,450,613
Тавант Толгой	28,870	384,584,510
АПУ	281,729	186,248,344
Дархан нэхий	2,793	66,525,300
Говь	2,039	48,950,840

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөвсгөл алтан дуулга	8,095.00	32.16% ▲
Жинст-Увс	1,850.00	26.63% ▲
Мерекс	36.80	22.67% ▲
ЛендМН ББСБ	46.12	21.34% ▲
Техник импорт	18,000.00	19.92% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ар Баянхангай	900.00	-21.74% ▼
Ган хийц	10,300.00	-14.88% ▼
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	150.00	-14.71% ▼
Могойн гол	7000.00	-10.14% ▼
Бөөний худалдаа	380.00	-5.00% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	759,561,624
Новел инвестмент	552,163,819
Ти Ди Би Капитал	541,737,673
Голомт Капитал	529,782,353
БиДиСек	414,993,570

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	662.54	705,062
Таван толгой	12,640.00	665,688
МИК	11,000.00	227,802
Говь	23,840.00	185,978
Сүү	238.00	81,872

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Нийт ногдол ашиг /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	587.7	56.6	2018.03.07	2018.03.27	2018.07.02-оос
2	AEL	Анд-Энерги ХК	13.3	0.5	2018.02.24	2018.03.16	N/A
3	SUL	Жуулчин дюти фрий ХК	653.6	10,000.0	2018.02.23	ХЭХ бүртгэлийн өдөр	2018.05.01-ээс
4	SUU	Сүү ХК	1,032.0	3.0	2018.02.14	2018.04.05	2018.12.31-ний дотор
5	GTL	Гутал ХК	2,055.7	1,270.0	2018.02.19	2018.03.18	2018.07.06-аас
6	BNG	Баянгол Зочид буудал ХК	150.2	355.0	2018.02.19	ХЭХ бүртгэлийн өдөр	2018.09.01-ээс
7	APU	АПУ ХК	10,641.8	10.0	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
8	BTG	Баянтээг ХК	25.3	100.0	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
9	MIE	Материалимпекс ХК	13.7	10.0	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
10	MNP	Монгол шуудан ХК	273.5	2.7	2018.02.13	2018.04.13	2018.05.01-ээс
11	MMX	Махимпекс ХК	380.1	100.0	2018.02.13	2018.04.05	2018.10.01-ээс
12	TCK	Талх чихэр ХК	174.0	170.0	2018.02.12	2018.04.06	2018.07.01-ээс
13	ADL	Адуун чулуун ХК	409.6	130.0	2018.01.24	2018.03.01	N/A
14	UBH	Улаанбаатар хивс ХК	40.4	100.0	2018.02.05	2018.02.26	2018.05.01-ний дотор
15	ТАН	Тахь-ко ХК	128.5	108.0	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
16	GOV	Говь ХК	1,716.2	220.0	2018.02.02	2018.03.27	2018.04.24-өөс
17	HRM	Гермес Центр ХК	392.7	5.0	2018.01.24	2018.02.15	2018.03.06-аас

ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
1	HRM	Гермес Центр ХК	2018-02-15	2018-03-07	15:00
2	NEH	Дархан нэхий ХК	2018-02-22	2018-03-17	-
3	BLG	Завханбаялаг ХК	2018-02-27	2018-03-19	10:00
4	VIK	Баян-Алдар ХК	2018-03-09	2018-03-27	10:00
5	ADL	Адуун Чулуун ХК	2018-03-01	2018-03-28	14:00
6	DLH	Эм Эн Ди ХК	2018-03-09	2018-03-28	15:00
7	BTG	Баянтээг ХК	2018-03-12	2018-04-02	10:00
8	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	2018-03-12	2018-04-02	11:00
9	BHL	Бөөний худалдаа ХК	2018-03-05	2018-04-04	13:00
10	HRD	Хүрд ХК	2018-02-23	2018-04-04	16:00
11	AZH	Алтайн зам ХК	2018-03-01	2018-04-04	16:00
12	HBT	Хөнгөн Бетон ХК	2018-03-13	2018-04-04	17:00
13	MNB	Мон Наб ХК	2018-03-14	2018-04-05	14:00
14	SSG	Сонсголон бармат ХК	2018-03-09	2018-04-06	10:00
15	GHC	Ган хийц ХК	2018-03-06	2018-04-06	11:00
16	DAZ	Дорнод авто зам ХК	2018-03-12	2018-04-09	15:00
17	GTL	Гутал ХК	2018-03-18	2018-04-09	15:00
18	HUZ	Хөвсгөл усан зам ХК	2018-02-26	2018-04-09	-
19	UBH	Улаанбаатар хивс ХК	2018-02-26	2018-04-10	11:00
20	OLL	Оллоо ХК	2018-03-19	2018-04-10	14:00
21	ALI	Стандарт Ноос ХК	2018-02-26	2018-04-10	15:00
22	ETR	Э-Транс ложистикс ХК	2018-03-23	2018-04-11	10:00
23	HUN	Увс хүнс ХК	2018-03-23	2018-04-13	9:00
24	BRC	Барилга Корпораци ХК	2018-03-16	2018-04-14	10:00
25	DBL	Даваанбулаг ХК	2018-03-24	2018-04-14	14:00

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
26	TEX	Техник импорт ХК	2018-03-28	2018-04-16	15:00
27	HUV	Хөвсгөл геологи ХК	2018-03-29	2018-04-17	10:00
28	GOV	Говь ХК	2018-03-27	2018-04-17	14:00
29	HVL	Хөвсгөл ХК	2018-03-28	2018-04-17	14:00
30	HHS	Хөвсгөл хүнс ХК	2018-03-28	2018-04-17	17:00
31	SOR	Сор ХК	2018-03-28	2018-04-18	10:00
32	TGS	Номин Хишиг ХК	2018-03-29	2018-04-18	10:00
33	HHN	Хархорин ХК	2018-03-30	2018-04-18	14:00
34	ARN	Сэлэнгэ Ар Хөвч ХК	2018-03-30	2018-04-18	14:00
35	MIE	Материалимпэкс ХК	2018-03-26	2018-04-20	10:30
36	TAV	Тав ХК	2018-03-28	2018-04-20	11:00
37	NOG	Ачит Алкабы ХК	2018-03-27	2018-04-20	15:00
38	APU	АПУ ХК	2018-03-29	2018-04-20	15:00
39	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	2018-03-27	2018-04-20	16:00
40	HSG	Хөсөг трейд ХК	2018-03-23	2018-04-21	12:00
41	AEL	Анд-Энерги ХК	2018-03-16	2018-04-21	12:00
42	CHR	Увс Чацаргана ХК	2018-03-23	2018-04-22	11:00
43	BNB	Баялаг Налайх ХК	2018-03-30	2018-04-22	15:00
44	SDT	Хот девелопмент ХК	2018-04-03	2018-04-23	10:00
45	BDS	Би Ди Сек ХК	2018-04-02	2018-04-23	10:00
46	BEU	Бэрх Уул ХК	2018-04-03	2018-04-23	12:00
47	MNS	Монноос ХК	2018-03-31	2018-04-23	15:00
48	UYN	Монгол савхи ХК	2018-04-05	2018-04-24	10:00
49	JGV	Жуулчин говь ХК	2018-04-05	2018-04-24	13:00
50	MNG	Мандал говь импекс ХК	2018-04-05	2018-04-24	15:00
51	BHG	Бөхөг ХК	2018-03-23	2018-04-25	10:00
52	TAH	Тахь-ко ХК	2018-03-30	2018-04-25	10:00
53	BUK	УБ-БҮК ХК	2018-04-03	2018-04-25	11:00
54	BBD	Стандарт проперти групп ХК	2018-04-10	2018-04-25	11:00
55	BDL	Могойн гол ХК	2018-04-04	2018-04-25	12:00
56	EER	Ариг гал ХК	2018-04-02	2018-04-25	17:00
57	HJL	Орхон хөгжил ХК	2018-04-03	2018-04-25	-
58	MMX	Махимпекс ХК	2018-04-05	2018-04-26	14:00
59	TTL	Таван Толгой ХК	2018-04-03	2018-04-26	14:00
60	SHG	Шарын гол ХК	2018-04-02	2018-04-26	15:30
61	UID	Улсын их дэлгүүр ХК	2018-03-30	2018-04-27	10:00
62	JTB	Женко Тур Бюро	2018-04-04	2018-04-27	10:00
63	MIB	Монинжбар ХК	2018-03-20	2018-04-27	11:00
64	MNH	Монгол Нэхмэл ХК	2018-03-30	2018-04-27	11:00
65	CHE	Хорго Хайрхан ХК	2018-04-06	2018-04-27	11:00
66	BUN	Булган ундрага ХК	2018-04-06	2018-04-27	11:00
67	ERS	Монгол алт ХК	2018-04-05	2018-04-27	11:00
68	SUN	Евроазиа капитал холдинг ХК	2018-03-20	2018-04-27	12:00
69	BOE	Эрчим баян өлгий ХК	2018-04-05	2018-04-27	12:00
70	GFG	Силк нэт ХК	2018-03-20	2018-04-27	14:00
71	ALD	Азык ХК	2018-03-28	2018-04-27	14:00
72	DZG	Дархан зочид буудал ХК	2018-03-28	2018-04-27	14:00
72	TCK	Талх Чихэр ХК	2018-04-06	2018-04-27	14:00
73	TEE	Тээвэр дархан ХК	2018-04-05	2018-04-27	14:00
74	MBG	Мон-Ит Булигаар Хк	2018-04-05	2018-04-27	9:00

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
75	MSC	Монгол Секюритиес ХК	2018-03-23	2018-04-28	13:00
76	JLT	Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК	2018-03-22	2018-04-28	14:00
77	TUS	Түшиг Уул ХК	2018-03-29	2018-04-28	14:00
78	MBG	Жинст-Увс ХК	2018-04-12	2018-04-28	14:00
79	MRX	Мерекс ХК	2018-04-07	2018-04-28	10:00
80	AMT	Хар хорум пропертийс ХК	2018-04-09	2018-04-28	12:00
81	ECV	Эрээнцав ХК	2018-04-09	2018-04-28	11:00
82	DAR	Дархан гурил тэжээл ХК	2018-04-10	2018-04-29	13:00
83	MOG	Монгео ХК	2018-04-09	2018-04-29	9:00
84	HCH	Е-Моние ХК	2018-04-08	2018-04-29	11:00
85	HBZ	Хүннү менежмент ХК	2018-04-08	2018-04-29	11:00
86	DOT	Дорнод тээвэр ХК	2018-04-08	2018-04-29	14:00
87	HSR	Хасу-Мандал ХК	2018-03-23	2018-04-29	15:00
88	NXE	Нэхээсгүй эдлэл ХК	2018-04-06	2018-04-30	9:00
89	ALA	Алтайн Нэгдэл ХК	2018-03-30	2018-04-30	10:00
90	BAZ	Люкс канаду групп ХК	2018-04-06	2018-04-30	10:00
91	GTJ	Булган гурил тэжээл ХК	2018-04-06	2018-04-30	11:00
92	BLC	Бүтээлч үйлс ХК	2018-04-05	2018-04-30	11:00
93	JGL	Говийн өндөр ХК	2018-04-09	2018-04-30	11:00
94	EAZ	Эрдэнэт авто зам ХК	2018-04-06	2018-04-30	11:00
95	NKT	Нако Түлш ХК	2018-04-03	2018-04-30	12:00
96	АНН	Хорин хоёрдугаар бааз ХК	2018-03-23	2018-04-30	13:00
97	HGN	Хөх ган ХК	2018-04-06	2018-04-30	14:00
98	HZB	Ган хэрлэн ХК	2018-04-06	2018-04-30	14:00
99	MSH	Монгол шилтгээн ХК	2018-04-06	2018-04-30	14:00
100	TAS	Эрдэнэт хүнс ХК	2018-03-31	2018-04-30	14:00
101	ITLS	Айтүүлс ХК	2018-04-06	2018-04-30	15:00
102	SUU	Сүү ХК	2018-04-05	2018-04-30	15:00
103	MDR	Фронтинер лэнд групп ХК	2018-04-06	2018-04-30	15:00
104	BSKY	Блюскай секьюритиз	2018-03-30	2018-04-30	18:00
105	DMA	Дэвшил Мандал ХК	2018-04-06	2018-04-30	9:00
106	INT	Ингэттолгой ХК	2018-04-09	2018-04-30	14:00
107	MIK	МИК Холдинг Хк	2018-04-11	2018-04-30	10:00
108	MNP	Монгол шуудан ХК	2018-04-13	2018-04-30	10:00
109	MCH	Монголын цахилгаан холбоо ХК	2018-04-06	2018-04-30	11:00
110	ONH	Өндөрхаан ХК	2018-04-12	2018-04-30	13:00
111	RMC	Ремикон ХК	2018-04-12	2018-04-30	11:00
112	TMZ	Төмрийн завод ХК	2018-04-09	2018-04-30	10:00
113	SOH	Уужим Хангай ХК	2018-04-12	2018-04-30	11:00
114	JRG	Эвлэл ХК	2018-04-09	2018-04-30	14:00

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Steppe Gold” компани Канадын зах зээлд IPO гаргах зөвшөөрөл авлаа

“Steppe Gold” компани Канадын зах зээлд IPO гаргахаар үнэт цаасны зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авсан тухайгаа албан ёсоор мэдээллээ. Ийнхүү тус компани Торонтогийн Хөрөнгийн биржээс 20-30 сая канад долларын хөрөнгө оруулалт татахаар хүлээж байна. Анхдагч зах зээлийн захиалга дөрөвдүгээр сарын 13 хүртэл үргэлжилнэ. Дөрөвдүгээр сарын 16-нд хувьцааны ханш тогтоогдоно гэдгийг албан эх сурвалж мэдээллээ. Харин арилжаалагдах “нэгж” нь нэг энгийн хувьцаа, 1.5 нэмэлт хувьцаа худалдаж авах эрхээс бүрдэж байна. Энэхүү эрхээр IPO гаргаснаас хойш 24 сарын дотор анхлан зах зээлд санал болгосон ханшийн 150 хувиар хувьцаа худалдаж авах боломжтой. “Haywood Securities” болон “Pi Financial” компаниуд хувьцааны захиалгыг хариуцах юм. Энэ онд “Алтан цагаан овоо” төслийн хүрээнд 20 мянган метр өрөмдлөг хийхээр төлөвлөж байна. Мөн уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж анхны олборлолтоо 2018 ондоо багтааж гаргахаар зорьж байна. Олборлосон алтаа Монголбанканд тушаана гэж тус компанийн удирдлага мэдээллээ. Мөн ойрын таван жилд энэ төсөлд 100 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, 200-250 хүн ажлын байраар хангана гэж тус компанийн Гүйцэтгэх захирал мэдээллээ.

Эргэн сануулахад “Steppe Gold” компани 2017 онд “Алтан цагаан овоо” ордыг 9.8 сая ам.доллараар худалдаж авсан аж.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Эрдэнэс Тавантолгой” ХХК IPO гаргахад “Дойче” банк хамтран ажиллах боломжтой гэв

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар өнөөдөр “Дойче” банк болон Европын сэргээн босголт хөгжлийн банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.

“Дойче” банкны Ази-Номхон далайн орнуудын харилцааны менежер Хайнз-Гүэнтэр Бокенхеймэр тэргүүтэй төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын үеэр сайд Д.Сумъяабазар Нью-Йорк хотноо хүлээн авч уулзсанд ноён Хайнз-Гүэнтэр Бокенхеймэрт талархаад, “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийг IPO гаргахад “Дойче” банк хамтран ажиллах боломжтой гэдгээ илэрхийлсэн юм. Түүнчлэн Монгол-Германы Засгийн газар хоорондын комиссын хуралдааны бэлтгэл ажлыг эхлүүлсэн талаар дуулгав.

Мөн УУХҮ-ийн сайд өнөөдөр Европын сэргээн босголт хөгжлийн банк /ЕСБХБ/-ны Уул уурхай, эрчим хүч хариуцсан Ерөнхий захирал Нандита Паршад тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр говийн аймгуудад усны асуудлыг шийдвэрлэхэд болон Алт-2 хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах, техник туслалцааны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зэргээр санал солилцлоо. ЕСБХБ-ны төлөөлөгчдийн зүгээс эдгээр саналуудад нааштай хандаж буйгаа энэ үеэр илэрхийлсэн юм.

Эх сурвалж: Montsame.mn



2017 онд ДЦС-ууд 795 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ

2017 онд Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг гурван цахилгаан станц нийт 795 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Ялангуяа Дулааны III цахилгаан станцын цэвэр ашиг хоёр дахин нэмэгдэж, 449 сая төгрөгт хүрчээ. Харин станцуудын борлуулалтын орлого нь 8-10 хувиар өссөн байна. 2016 онд гадаад валютын зөрүүнээс гарз хүлээж байсан бол 2017 онд нөхцөл байдал сайжирсан гэдгийг эх сурвалжууд мэдээлж байсан юм. Дулааны IV цахилгаан станцаас өгсөн мэдээллээр өнгөрсөн онд эрчим хүч нийлүүлэлтийн зорилтоо 180 сая кВт цагаар давуулсан бол дулаан нийлүүлэлтийн төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн байна. Мөн “Санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах ажилд түлхүү анхаарсан. Тэвчиж болох зардлуудыг хэмнэсэн” гэдгийг онцолжээ. Түүнчлэн төвийн бүсийн Дулааны цахилгаан станцууд нээлттэй хэлбэрээр нийлүүлэлтийн тендер зарлах тоо нэмэгдүүлсэн нь ашгаа өсгөхөд голлон дэмжлэг үзүүлсэн байна.

IV дулааны цахилгаан станцын хувьд өнгөрсөн онд 119 төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэх тендер зарласан нь 2016 оныхоос хоёр дахин өсжээ. 2018-2019 оны их засварын хүрээнд “ДЦС-4” ТӨХК-ийн турбингенератор №1, 2, 3, 4-ийн насжилтыг уртасгах, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил хийгдэнэ. Засвар хийгдсэнээр цахилгааны хүчин чадал 89 мВт-аар, дулаан 150 ккал/цагаар, насжилт 35 жилээр нэмэгдэх юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



MARKETINFO: МХБ-д бүртгэлтэй 100 ХК-ийн борлуулалтын орлого 38.6 хувиар өссөн

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 100 хувьцаат компанийн санхүүгийн үр дүнг нэгтгэн тооцоход борлуулалтын орлого нь 38.6 хувиар өссөн гэж marketinfo.mn мэдээллээ. Эдгээр 100 хувьцаат компанийн борлуулалтын орлого 2017 онд нийт 1.45 их наяд төгрөгт хүрч өссөн байна. Орлогын өсөлтийн дийлэнхийг “ТОП 20” индексийн сагсанд багтдаг компаниуд бүрдүүлж байгаа юм. Үүнээс “Тавантолгой” компанийн борлуулалтын орлого хамгийн их хэмжээгээр өсжээ. Тус компани 2017 онд 427.9 тэрбум төгрөгийн орлого олсон нь 2016 оноос 251.4 тэрбум төгрөг буюу 142.4 хувиар өссөн байна. Судалгаанд хамрагдсан 100 хувьцаат компанийн ашгийн үзүүлэлтийг харвал 59 хувь нь ашигтай ажиллаж, нийт 269.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Компаниудын ашгийн хэмжээ 2016 оноос 81.4 хувиар өссөн байна. Харин алдагдалтай ажилласан компаниуд нийт 13.5 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн талаар marketinfo.mn мэдээллээ.

Эх сурвалж: Montsame.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Ашигт малтмалын олборлолтын хэмжээ нэмэгджээ

Монголын үйлдвэрлэлийн геологчдын холбооны санаачилгаар зохион байгуулдаг “Монголын геологи хайгуул-2018” чуулга уулзалт “Корпорейт Конвеншн төв”-д 10 дахь удаагаа болов.

“Монголын геологи, хайгуул-2018” чуулга уулзалтын хүрээнд Засгийн газраас эрдэс баялгийн салбарт баримталж буй бодлого, хууль эрхзүйн орчин, түүний хэрэгжилт, ашигт малтмалын геологийн судалгаа, ордын эрэл хайгуулын аргачлал, техник технологид оролцогсод төвлөрч санал бодлоо солилцлоо.

Эрдэс баялгийн салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд алт, зэс зэрэг зарим ашигт малтмалын олборлолтын хэмжээ нэмэгдсэн. Хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгож хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн, төвлөрлийг сааруулж орон нутагт барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж зэрэг олон давуу тал бүрдсэнийг онцолж байна.

Мөн геологи уул уурхайн төслүүдийн үр дүн, эрдэс баялгийн салбарын өнөөгийн байдлын талаар хуралдаан, хэлэлцүүлэг өрнөсөн юм.

Ашигт малтмалын ордын хайгуул, уул уурхайн ашиглалтын төслүүдийн танилцуулга, хөрөнгө оруулагчдын бизнес уулзалт, байгууллагуудын танилцуулга, үзэсгэлэнг мөн үеэр гаргажээ. Мөн “Алдарт геологич”, “Зураглалын шилдэг баг”, “Хайгуулын шилдэг баг” шалгаруулах ёслол, Оюутны эрдэм шинжилгээний бага хурал, “Монгол орны байгаль – Хайгуулчдын дуранд”, “Эрдэс чулуулгийн цуглуулга, дээжис” үзэсгэлэн зэрэг олон арга хэмжээг нэг дор зохион байгуулав.

“Монголын геологи хайгуул-2018” чуулга уулзалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Монгол улсын их сургууль, ШУА, Палеонтологи, геологийн хүрээлэн, Монголын үйлдвэрлэлийн геологчдын холбоо хамтран зохион байгуулж байна. “Монголын геологи хайгуул-2018” чуулга уулзалт маргааш өндөрлөнө.

Эх сурвалж: Montsame.mn

TRQ: “Оюу Толгой”-ийн гүний уурхайн V босоо амны нэвтрэлт эцсийн гүнд хүрсэн

“Оюу Толгой”-ийн гүний уурхайн V босоо амны нэвтрэлтын ажлыг гүйцэтгэж, эцсийн гүн буюу 1178 метрийн гүнд хүрсэн талаар “Turquoise Hill Resources” компани мэдээллээ. 2017 оны IV улиралд энэхүү V босоо амны бохир агаар зайлуулах сэнс суурилуулах ажлыг эхэлж, 2018 оны II улиралд бүрэн дуусгахад төлөвлөжээ. V босоо ам нь 6.7 метрийн диаметртэй, агааржуулалтын үүрэгтэй хоолой бөгөөд улмаар энэ нь гүний уурхайн үйл ажиллагааны хүчин чадлыг сайжруулахад тустай юм байна. Үүнээс гадна II босоо амны нэвтрэлтийг нэгдүгээр сард дуусгажээ. 2018 оны туршид тоноглолын ажлуудыг хийхээр төлөвлөж байгаа аж. Ийнхүү гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил амжилттай үргэлжилж байгаа гэдгийг “Turquoise Hill Resources” компани онцолж байна. Харин хувьцааны ханшийн хөдөлгөөнийг харвал Торонтогийн Хөрөнгийн биржид мягмар гарагт 1.17 хувиар буурчээ. “Rio Tinto”-ийн хувьцааны ханш Австралийн Хөрөнгийн биржид 0.67 хувиар өсөж лхагва гарагийн арилжааг эхэллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Morgan Stanley: “Хөнгөн цагаан” хөрөнгө оруулалтын өгөөж хамгийн өндөр түүхий эд

“Morgan Stanley” хөрөнгө оруулалтын өгөөж өндөртэй түүхий эдээр хөнгөн цагааныг нэрлэлээ. 2017 онд 34 хувиар өссөн хөнгөн цагааны ханш 2018 он гарснаас хойш найман хувийн бууралттай байна. Гэсэн ч БНХАУ-ын хэрэгжүүлж байгаа гарц танах хөтөлбөр үр дүнгээ өгч үнэ эргээд сэргэнэ гэж “Morgan Stanley” тооцоолж байгаа юм. Мөн хөнгөн цагааны эрэлт өсөж, өртөг нэмэгдэж байгаа нь үнэ өсгөх хүчин зүйл болох ажээ. “Morgan Stanley”-ийн шинжээчдийн дүгнэлтээр хөнгөн цагааны үнэ илүүдэл нийлүүлэлтээс шалтгаалж ирэх улиралд 2072 ам.доллар хүрч буурах ч 2018 оны эцсээр 2116 ам.доллар болж өсөх төлөвтэй байна. Одоогоор хөнгөн цагааны ханш 2079 орчим ам.долларт хэлбэлзэж байна. Харин нөгөө талаас гарц танах хөтөлбөрөөс үл хамааран БНХАУ-д хөнгөн цагааны гарц нэмэгдсээр байгааг Блумбергийн шинжээчид онцолж байна. Энэ нь богино хугацаандаа үнэ буурах шалтгаан болно гэж мөн шинжээчид дүгнэжээ. Энэ онд хөнгөн цагааны нийлүүлэлт 3.7 сая тонноор нэмэгдэх төлөвтэй байгаагийн 68 хувийг Хятад улс дангаар бүрдүүлэхээр байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



Дэлхийн геополитикийн эрсдэлийн индекс 15 жилийн дээд түвшиндээ хүрчээ

Дэлхийн геополитикийн эрсдэлийн индекс 15 жилийн дээд түвшиндээ хүрч өссөнийг хөрөнгө оруулалтын “Saxo” банк мэдээллээ. Энэ нь алтны зах зээлийн “тайван” байдлыг эвдлэх өндөр магадлалтай гэж шинжээчид үзэж байна. Алтны ханш хувиар бол 2012 оноос хойших харин ам.доллараар 2007 оноос хойших хамгийн савлагаа багатай үедээ байгаа юм. Гэхдээ олон улсын улс төр, геополитикийн эрсдэлүүд болон эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн өөрчлөлтүүд зах зээлийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Алтны ханш өнгөрсөн баасан гарагт 2018 оны хамгийн доод цэгтээ хүрсэн ч энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 80 ам.доллараар өндөр болжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Монголбанк мөнгөний бодлогын хүүг нэг нэгж хувиар бууруулж, 10 хувь болгов

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл өнөөдөр хуралдаж, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувь болголоо. Мөн хурлаар Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 10.5 хувь, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 12 хувиар тогтоох шийдвэр гаргажээ. Бодлогын энэхүү шийдвэр нь банкны салбарын богино хугацаатай эх үүсвэрийн хүүг бууруулж, улмаар зээлийн хүүгээр дамжин бизнесийн идэвхжлийг дэмжинэ хэмээн Мөнгөний бодлогын зөвлөл үзжээ. Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа хэлэхдээ, "Бодлогын хүү буурснаар банкны салбарын өртөг буурч, эдийн засагт дэмжлэг болно. Инфляци зорилтот түвшинд хадгалагдах төсөөллийг үндэслэн хүүг нэг нэгж хувиар буурууллаа" хэмээв. Торуулбал, эрэглээний үнийн индексээр илэрхийлсэн жилийн инфляци өнгөрсөн хоёрдугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.9 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 8.1 хувьтай байна. Гадаад эрэлт хүлээлтээс сайжирч, экспортын бүтээгдэхүүний үнэ өндөр түвшинд хадгалагдаж төлбөрийн тэнцэл болон эдийн засгийн төлөвт эерэг нөлөө үзүүлж буйг албаныхан онцлов. Эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэж байгаа ч жилийн инфляци цаашид зорилтот түвшинд байна гэсэн хүлээлт байна. Бодлогын хүү хэдэн хувь байхаас арилжааны банкуудын зээлийн хүү хэр өндөр байх нь хамаардаг.

Эх сурвалж: Montsame.mn

Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр нэмлээ

Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр нэмж, 1.75 хувьд хүргэлээ. Энэ нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа юм. АНУ-ын эдийн засаг цаашид үргэлжлэн өсөж, хөрөнгийн зах зээл өндөр өсөлтөө хадгална гэж тус улсын Төв банкны удирдлагууд таамагласан байна. Үүнтэй холбоотойгоор энэ онд дахин хоёр удаа бодлогын хүүг нэмэхээр тооцоолсон талаар мэдэгджээ. Үүнээс гадна АНУ-ын Төв банк ирэх хоёр жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн таамгаа нэмэгдүүлсэн байна. Тодруулбал, энэ онд АНУ-ын эдийн засаг 2.7 хувиар, ирэх онд 2.4 хувиар өснө гэж таамаглажээ. "Төсвийн бодлого тогтворжиж, татварын шинэчлэл хийсэн зэрэг нь эдийн засгийн төлөвт эерэгээр нөлөөлж байна. Ажлын байрны тоо өсөлтөө хадгалах нь орлого болон бизнесийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй" гэж Холбооны Нөөцийн банкны шинэ тэргүүн Жером Пауэлл онцлов. Түүнчлэн тэрбээр "Сүүлийн гурван сарын хугацаанд шинээр ажилд орсон хүмүүсийн тоо сард дунджаар 240 мянгаар өслөө. Мөн ажилгүйдлийн түвшин хоёрдугаар сард 4.1 хувьд хадгалагдаж, эдийн засаг дахь ажиллах хүчний оролцоо өсөн нэмэгдсэн. Тийм учраас хөдөлмөрийн зах зээл цаашид өсөлттэй байна гэж бид таамаглаж байна. Инфляц энэ онд 1.9 хувьд хүрч, зорилтот түвшинд дөхнө гэж бид тооцоолж байна. Үүгээр ч зогсохгүй ирэх онд хоёр хувьд, 2020 онд 2.1 хувьд хүрэх төлөвтэй байна. Хэдий тийм боловч бидний өмнө эрсдэл тулгарч байгаа. Хэрвээ бид бодлогын хүүг яаран өсгөвөл, инфляц Төв банкны зорилтот хоёр хувьд хүрэхэд хүндрэлтэй. Энэ нь эсрэгээр бидэнд дарамт учруулна. Тиймээс бид тохиромжтой цаг үеийг хүлээж, шийдвэрээ гаргах хэрэгтэй. Ингэснээр эдийн засгийн өсөлт ч тогтвортой түвшинд хадгалагдах боломжтой" гэж мэдэгдлээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

БНХАУ-ын Төв банк мөнгөний бодлогоо чангатгав

Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ өсгөсний дараа БНХАУ-ын Төв банк мөнгөний бодлогоо чангатгах алхам хийлээ. БНХАУ-ын Ардын банк арилжааны банкуудад олгодог богино хугацаатай зээлийн хүүгээ таван суурь нэгжээр нэмэгдүүлсэн байна. Ийнхүү БНХАУ-ын Төв банкны шинэ тэргүүн И Ган томилогдсоноосоо хойших анхны шийдвэрээ гаргалаа. Тэрбээр "Цаашид мөнгөний хянамгай бодлого баримтална" гэдгээ мэдэгдээд байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

60 тэрбум ам.доллараар үнэлэгдэх БНХАУ-ын бараа, бүтээгдэхүүнд АНУ импортын татвар ногдуулна

Дональд Трампын засаг захиргаа 60 тэрбум ам.доллараар үнэлэгдэх БНХАУ-ын зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнд импортын татвар ногдуулахаар төлөвлөж байгаа талаар ойрын эх сурвалж мэдээллээ. Хэрэглээний цахилгаан бараанаас эхлээд БНХАУ-д үйлдвэрлэсэн гутал, хувцас зэрэг бараа, бүтээгдэхүүнүүд энэ жагсаалтад багтаж магадгүй байгаа ажээ. Түүнчлэн АНУ-д хийх БНХАУ-ын хөрөнгө оруулалтад ч хязгаарлалт тавьж болзошгүй гэдгийг эх сурвалж дурдсан байна. БНХАУ Америкийн бизнес эрхлэгчдээс оюуны өмч хулгайлсан гэж АНУ-ын засаг захиргаа үзэж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор шийдвэрээ энэ долоо хоногт багтаан баталгаажуулж магадгүй байгаа юм. Үүнээс өмнө Дональд Трамп 30 тэрбум ам.доллараар үнэлэгдэх бараа, бүтээгдэхүүнд татвар ногдуулах саналаас татгалзаж, хэмжээг нь нэмэгдүүлэхийг үүрэг болгосон талаар "Washington Post" мэдээлжээ. Харин мягмар гарагт БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Кэцян "БНХАУ цаашид эдийн засгаа илүү нээлттэй болгож, зарим бараа, бүтээгдэхүүний импортын татварыг бууруулна" гэж байр сууриа илэрхийлсэн байна. Үүгээр зогсохгүй гадаадын компаниудыг технологио нэвтрүүлэхийг шаардахгүйгээр оюуны өмчийг дээдэлнэ гэдгээ онцолжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

"Фэйсбүүк" компанийн үүсгэн байгуулагч Марк Цукерберг алдаагаа хүлээн зөвшөөрчээ

"Фэйсбүүк" нийгмийн сүлжээг үүсгэн байгуулагч Марк Цукерберг компаниа улс төрийн зорилгоор ашиглаж, хэрэглэгчдийн нууц мэдээллийг задраасан ноцтой асуудал гаргасан алдаагаа хүлээн зөвшөөрсөн тухай "Синьхуа" агентлаг мэдээлэв.

"Бид алдаа гаргасан гэхдээ л хийх зүйл их байгаа бөгөөд идэвхтэй ажиллаж тэдгээрийг хийж гүйцэтгэх шаардлагатай байна" гэж М.Цукерберг хэлжээ.

Фэйсбүүкийн 50 сая гаруй хэрэглэгчийн мэдээллийг "Cambridge Analytica" хэмээх Британийн мэдээллийн шинжилгээний компани 2016 онд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн Дональд Трампын сонгуулийн кампанит ажилтай холбоотойгоор урвуулан ашигласан тухай АНУ болон Их Британийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлсний дараа Фэйсбүүк компани хүнд байдалд орсон байна.

"Манай компани алдаа дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах болно" гэж "Фэйсбүүк" компанийн тэргүүн батлан илэрхийлжээ.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.